

**УВС АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД  
БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ БАНЬД ОВОГТОЙ АЛТАНБИЛЭГ-ийн МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

**НЭГ : ГЭР БҮЛИЙН ХӨГЖИЛ, ХУВЬ ХУНИЙ ХӨГЖИЛ, ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ**

**1.1 Гэр бүл, хувь хуний хөгжил**

- 1.1.1 Хорт хавдрын эрт үеийн илрүүлэлт, урьдчилан сэргийлэлтэд онцгойлон анхаарч ажиллана.
- 1.1.2 Багш нарын мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжиж, мэргэжил дээшлүүлэх гадаад, дотоодын сургалт, үйл ажиллагаанд хамруулна.
- 1.1.3 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ердийн сургууль, цэцэрлэгт суралч, хөгжих орчныг бүрдүүлж ажиллах тал дээр анхаарна.
- 1.1.4 Инженерийн дэд бүтэц бүхий хувийн сууц барьж буй өрхийг ипотекийн зээлд хамруулах ажлыг дэмжиж ажиллана.
- 1.1.5 Хүүхдийн хөгжил, авьяас, ур чадвар, техник сэтгэлгээ, нийгмийн төлөвшлийг дэмжихэд эцэг, эхчүүдийн оролцоог нэмэгдүүлэх ажлуудыг хэрэгжүүлнэ.
- 1.1.6 Хүүхдийн тоглоомын талбай, орчны стандартыг мөрдүүлж, хүүхдэд аюулгүй орчин бүрдүүлж ажиллана.
- 1.1.7 Гэр бүл, хүүхэд, оюутан, залуучууд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх орчин бий болгоход анхаарч ажиллана.
- 1.1.8 Ахмад настны чөлөөт цагаа өнгөрөөх, мэдээлэл авах, хөгжих боломжийг бүрдүүлэх хөгжлийн төвүүдийг сумдад бий болгож ажиллахыг ИТХ-р батлуулах талаар анхаарч ажиллана.

**1.2 ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ**

- 1.2.1 Малчид, тариаланчдын сайхан амьдрах орчныг сайжруулж тогтвортой орлогын эх үүсвэртэй болгоход анхаарна.
- 1.2.2 Арьс, шир, ноос, ноолуур, түүхий эд, сүү, махны зах зээлийн үнийг тогтвортой барьж ажиллах талаар анхаарч ажиллана.
- 1.2.3 Мал эрүүлжүүлэх, чанар, ашиг шимийг сайжруулах ажил, малын тоог чанарт шилжүүлэх ашиг шим, хүртээмжийг сайжруулах талаар дүрэм журам боловсруулж болно.
- 1.2.4 Малчид, тариаланчдын өрхийн аж ахуйд дээмжлэг туслалцаа үзүүлэх замаар хүн амын мах, сүүний хэрэгцээг органик хүнсээр тогтвортой хангана.
- 1.2.5 Монгол Улсын Засгийн Газар бусад холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж зээлээр хөнгөн үйлдвэр, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжих арга хэмжээг зохион байгуулж ажиллана.
- 1.2.6 Суманд үсчин, зурагчин, гутал, зурагт, гар утас засвар, оёдлын гэх мэт үйлчилгээний нэгдсэн төвийг байгуулах ажлын байрыг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.
- 1.2.7 Увс, Хяргас нууруудыг дагасан өвөл, зуны аялал жуулчлалын цогцолбор бий болгон хөгжүүлж ажиллана.

**ХОЁР: БАЙГАЛЬ ОРЧНЫ ХӨГЖИЛ, СУМЫН ХӨГЖИЛ**

**2.1 Байгаль орчны хөгжил**

- 2.1.1 Цөлжилтийг бууруулах, хөрс хамгаалах, байгаль орчинг сэргээх, ган зудын болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэхийн үүднээс тариалангийн талбайн газрын тусгай хэрэгцээний газраар авч шийдвэрийг ИТХ гаргуулах
- 2.1.2 Малчдын хүсэлт, хэрэгцээ шаардлагыг харгалзан үзэж бэлчээрийг усжуулах, худаг ус гаргах ажлыг зохион байгуулах.
- 2.1.3 Иргэдийн уул уурхайд тавих хяналт, оролцоог сайжруулж хууль зөрчиж олгогдсон тусгай зөвшөөрлүүдийг цуцлуулах саналыг холбогдох төрийн байгууллагад хүргүүлнэ.

**2.2 Сумын хөгжил**

- 2.2.1 Ногоон байгууламжуудыг нэмэгдүүлэн хүүхдийн чөлөөт цагаа өнгөрөөх аюулгүй орчныг бүрдүүлж ажиллана.
- 2.2.2 Суманд гэр хорооллын дэд бүтцийн ажлыг эхлүүлж хашаандаа сайхан амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.